



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар A/182

Улаанбаатар хот

Хөтөлбөр, журам батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн Захирлын 2020 оны А/125 тоот тушаал, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Авьяасыг дэмжих хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Авьяастныг дэмжих түр журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Батлагдсан хөтөлбөр, түр журмыг их сургуулийн үйл ажиллагаанд баримтлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан), бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн захирал, дарга наарт үүрэг болгосугай.
- Тус хөтөлбөр, түр журмыг 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ



# АВЬЯАСЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

(2020-2025)



## АГУУЛГА

НЭГ. ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО.....	5
ГУРАВ. ҮНДСЭН ЗАРЧИМ.....	5
ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ.....	5
ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ.....	7
ЗУРГАА: ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ.....	7
ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАГНАЛ, ҮНЭЛГЭЭ.....	7

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Дэлхий даяарчлагдсан өнөө үед нийгмийн харилцаанд мэдээллийн техник, технологийн дэвшилд нэвтрэхийн хирээр хүний байгалиас заяагдмал төрөлх шинж саармагжиж, амьдралын үнэт зүйлийн тухай ойлголт өөрчлөгдөн уламжлалт ёс суртахууны үнэ цэнэ буурсаар байна.

Дэлхийн улс орнууд суралцагч, судлаачдын туршилт, судалгааны авьяас, ур чадварт ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд нийтлэг тэтгэлэгт хөтөлбөрүүдээс илүү шинэ санаа гаргах, зохион бүтээх мэдлэгийг нэн тэргүүний шалгуур үзүүлэлт болгож, ялгаатайгаар авч үздэг болсон байна. Тухайлбал:

- Өнөөдрийн авьяастан Маргаашийн манлайлагч (Talents Today – Leaders Tomorrow)
- Ирээдүйн хөрөнгө оруулалт (Future Investments)
- Авьяаслаг шинжлэх ухаанч оюутан (Talented Science Students)

Гэх мэт олон хөтөлбөрүүдээр дамжуулан авьяастныг дэмжих санг хэрэгжүүлж байна.

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 2.7 дахь заалтад “Суралцагчийн онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих тухай...”, Дээд боловсролын тухай хуулийн “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай”, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам” Монгол улсын ерөнхийлөгчийн “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” зарлиг, “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам” “Боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичиг” болон шинжлэх ухааны бусад эрх зүйн баримт бичгүүдийг батлуулан мөрдөн ажиллаж байгаа хэдий ч Монгол хүнээ дээдлэн хөгжүүлэх, мэдлэг, авьяас чадварыг дэмжих, их дээд сургуульд чадварлаг мэргэжилтэнг бэлтгэх, мэдлэгийн орон зайд бий болгох, тэлэх асуудал тусгагдаагүй байна.

Монгол улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүд, Засгийн газрын хөтөлбөр, шинжлэх ухаан, технологи, үйлвэрлэлийн уялдаа холбоог хөгжүүлэх бодлого, тэргүүлэх чиглэлийн мэдлэгийг баялаг болгож эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар олон зүйл заалтууд орсон байдаг. Хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох эдгээр баримт бичгүүдийг тогтвортой хэрэгжүүлэхэд их, дээд сургуулиуд, тэнд ажиллах авьяастан голлох тулгуур, хөдөлгөгч хүч нь болох ёстой.

Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд хийгдсэн судалгааны үр дунгээс харахад Монголын дээд боловсролын гадаад болон дотоод орчны нөлөөллийг үнэлсэн үзүүлэлтийн авьяасыг дэмжсэн байдлаараа дэлхийн 63 орноос Монгол улс хамгийн сүүлд орсон байна. Судалгаагаар Монгол улсын их сургуулиудад олон давуу тал, боломжууд байгааг харуулсан хэдий ч чадварлаг эрдэмтэн судлаачдын манлайлал нь сул, авьяасын төвлөрөл бүрдээгүй, ахисан түвшний сургалт нь судалгаанд суурилсан гэхээс илүү сургалт давамгайлсан, үндсэн судлаач суралцагч байхгүй, гадны өрсөлдөгч сургуулиудад авьяастнуудаа алдах магадлалтай ихтэй зэрэг сул талууд давамгай байгааг харуулсан.

Иймд инновацийн гол тоглогч их дээд сургууль болж байгаа энэ үед ШУТИС-ийн “Авьяасыг дэмжих” хөтөлбөр нь дээрх сул талуудыг багасгаж өөрийн давуу тал болгон өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулахаас гадна Монгол улсын дээд боловсролын салбарт эрс өөрчлөлт оруулах шинэ алхам бий болох юм.



“ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг батлуулсан бөгөөд судалгаанд суурилсан их сургууль болох зорилтын хүрээнд 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн өнөөгийн зорилго, хүртээмж, чанарын асуудлыг шинээр тодорхойлон суралцагч, судлаач, хамт олны мэдлэг, ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ахисан түвшний сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний үр дүнг сайжруулах зорилгоор “Авьяасыг дэмжих” хөтөлбөр болон холбогдох журмыг боловсруулан батлуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн инженер техникийн авьяастны төвлөрлийг бий болгох, тэдний хамтын нэгдмэл үйл ажиллагааг дэмжин, хүний нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

- **ШУТИС-ИЙН АЛСЫН ХАРАА**

Дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ.

- **ШУТИС-ИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО**

Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацийг бүтээх авьяас чадварын төвлөрөл байна.

### **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО**

Их сургуулийн ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний биелэлт хэрэгжилтийг хангах хүрээнд сургалт, судалгаа, инноваци, нийгмийн хариуцлага, засаглал менежмент гэсэн таван үндсэн чиглэлээр авьяастныг татан төвлөрүүлэх, хөгжүүлэх, дэмжин урамшуулах замаар судалгааны их сургуулийн үндэс суурийг тавьж, хүний нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### **ГУРАВ. ҮНДСЭН ЗАРЧИМ**

1. Чадварлаг суралцагч, судлаач, ажилтныг авьяас хөтөлбөр тэгш боломжоор хангах
2. Мэдлэг, чадвар, хандлага төлөвлөшөөр үнэлэх, хөгжүүлэх
3. Академик эрх чөлөөг дээдлэх

### **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ**

ШУТИС нь Монгол улсын шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэрийн салбарын өнөөгийн болон ирээдүйн хөгжилд бодит хувь нэмэр оруулах, улс орны нийгэм-эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн, үйлдвэрлэл, практикт нэвтэрч үр ашигтай хэрэглээ болохуйц эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлыг эрчимжүүлж, дэлхийн шилдэг их сургуулиудын жишгээр сургалтад суурилсан тогтолцооноос орчин үеийн судалгаанд суурилсан их сургууль болохын тулд дараах зорилтуудыг тавин ажиллаж байна.

**ЗОРИЛТ 1:** Өндөр мэдлэг, ур чадвартай авьяаслаг суралцагч, судлаач, ажилтныг сонгон шалгаруулж, урамшуулан, төвлөрлийг бий болгоно.

**ЗОРИЛТ 2:** Гадаад, дотоодын их, дээд сургуулиас туршлагатай өндөр түвшний зочин профессорыг урьж ажиллуулах, авьяастныг солилцооны журмаар туршлага судлуулж, олон улсын суралцагчдыг татах бодлого хэрэгжүүлнэ.

**ЗОРИЛТ 3:** Авьяастныг бүх түвшинд дэмжих авьяас сан бий болгож, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.



#### **4.1 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 4.1.1 Бакалаврын суралцагчдыг авьяастны дэмжлэгт хамруулах замаар татан төвлөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 4.1.2 Шинэ бүтээлч санаа, шийдэл дэвшүүлсэн бакалаврын суралцагчдыг дэмжиж, цаашид ахисан түвшинд суралцуулахад дэмжих;
- 4.1.3 Магистрант, докторантыг “Авьяастныг дэмжих түр журам”-ын дагуу сонгон шалгаруулж, бүтэн цагаар элсүүлэн тэтгэлэгтэйгээр суралцуулах;
- 4.1.4 Ахисан түвшний суралцагчдаас авьяас чадвартай судлаачдыг туслах багш, сургалтын инженер, судлаачаар ажиллах боломжийг бүрдүүлэх;
- 4.1.5 Докторын дараах судлаачийг (Post-doc) үр дүнгийн гэрээгээр ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- 4.1.6 Нийгмийн түншлэлийн хүрээнд төрийн болон төрийн бус бизнесийн мэргэжлийн байгууллагуудтай их сургуулийн сургалт судалгааны үйл ажиллагааны чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, инноваци шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгож буй багш, судлаачдыг дэмжих хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 4.1.7 ШУТИС-ийн удирдлага, багш, ажилтнуудад манлайллын сургалт тогтмол явуулах, шинэ үеийн манлайллагчдыг бэлтгэх;
- 4.1.8 Багш, ажилтнуудын албан тушаалын зэрэглэл, ажлын ачаалал, цалин хөлс, урамшууллын системийг шинэчлэн, авьяас ур чадвар бүхий хүмүүсийг сонгон шалгаруулж, татан төвлөрүүлэх, тогтоон барих;
- 4.1.9 Мэргэжлийн болон судалгааны ёс зүйн хэмжээг тогтоож, хэвшүүлэх;
- 4.1.10 Авьяастыг багаар хамтран ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх, судалгааны багийн системийг хөгжүүлэх;
- 4.1.11 Судалгааны ажлын үр дүн гүйцэтгэлийн үнэлгээ, чанарыг сайжруулах;
- 4.1.12 Сургах, суралцах үйл ажиллагаанд инноваци, дэвшилтэт технологи нэвтрүүлж буй багшийг дэмжих.

#### **4.2 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 4.2.1 Гадаад, дотоодын их, дээд сургууль, сургалт судалгааны байгууллагаас өндөр түвшний зочин профессорыг урилгаар ажиллуулах;
- 4.2.2 Авьяастныг багшийг гадаад, дотоодын их, дээд сургууль, судалгааны байгууллагад туршлага судлуулах, хамтарсан судалгааны ажил гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх;
- 4.2.3 Сургалтын хөтөлбөрийн чанарыг дээшлүүлж, гадаад хэл дээр сургалтыг явуулж, олон улсын суралцагчдыг төвлөрүүлэх;
- 4.2.4 ШУТИС-ийн авьяастныг сургалт, судалгааны чиглэлийн дагуу аж үйлдвэрийн салбарт ажиллуулах, туршлага хуримтлуулах боломж, нөхцлийг бүрдүүлэх;
- 4.2.5 Тухайн салбарт манлайлагч мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудыг судалгааны ажилд татан оролцуулах, харилцан туршлага судлах боломжоор хангах.

#### **4.3 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 4.3.1 Авьяасыг дэмжих санхүүгийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх;
- 4.3.2 ШУТИС-ийн хэмжээнд авьяастныг дэмжих нэгдсэн Авьяас сан бий болгох;
- 4.3.3 Авьяас сангийн санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, хуримтлуулах зарцуулахтай холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх;



- 4.3.4 Авьяас хөтөлбөр хэрэгжих 1 дүгээр үе шатанд Авьяас сан цаашид бие даан ажиллах суурь нөхцлийг хангах;
- 4.3.5 Авьяас сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх.

### ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

- 5.1 Авьяасыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг дараах байдлаар бүрдүүлнэ. Үүнд:
- 5.1.1 Улсын төсвийн хөрөнгө
  - 5.1.2 ШУТИС-ийн төсвийн хөрөнгө
  - 5.1.3 Гадны байгууллагын нэрэмжит тэтгэлэг
  - 5.1.4 Хандив, тусламж
  - 5.1.5 Бусад эх үүсвэр

### ЗУРГАА: ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

- 6.1 Хөтөлбөрийг хоёр үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1 дүгээр үе шат 2020-2023
  - 2 дугаар үе шат 2023-2025

### ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАГНАЛ, ҮНЭЛГЭЭ

- 7.1 ШУТИС-ийн бүтцийн нэгж бүр уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжилтийг тайлagnana.
- 7.2 Хөтөлбөрийн хэрэгжилт нь ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний үндсэн үзүүлэлт болон холбогдох шалгуур үзүүлэлтийг (KPI) хангахад чиглэсэн байна.

Хүснэгт 1: Авьяасыг дэмжих хөтөлбөрийн гүйцэтгэлийн тулхүүр үзүүлэлт

№	Хэмжих үзүүлэлт	2019 оны суурь түвшин	1-р үе шат (2020-2023)	2-р үе шат (2023-2025)
1	Нийт суралцагчдын гадаад суралцгчийн эзлэх хувь	<0.2%	0.5%	2%
2	Гадаад багшийн эзлэх хувь	<0.02%	4%	9%
3	Нийт орлогоос суралцагчдад олгосон тэтгэлгийн хэмжээ	<0.1%	0.1%	0.3%
4	Гадаад хэл дээр явагдах бакалаврын сургалтын хөтөлбөрийн тоо	0	10	12
5	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	38%	47%	60%
6	Нэг багшид оногдох олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн санд бүртгэлтэй бүтээлийн тоо	0.6	2	5
7	Нийт орлогод судалгаа, инновацийн орлогын эзлэх хувь	12%	25%	40%

8	Нийт зардалд судалгаа, инновацид зарцуулсан зардлын эзлэх хувь	8.2%	20% 161 ... 9087 087	30%
9	Бакалавр ба магистр, доктор суралцагчийн тооны харьцаа	9:1	9:2	9:4
10	Нийт суралцагчдаас тэтгэлэг хүртсэн суралцагчдын эзлэх хувь	15%	20%	35%
11	Нийт орлогод эзлэх оюутны тэтгэлэгт олгосон хувь	<0.1%	0.1%	0.3%
12	Олон улсын уралдаан тэмцээнээс хүртсэн шагналын тоо	<10	10	30
13	Төгсөгчдийн үргэлжлүүлэн суралцах байдал	10%	12%	14%
14	Англи хэлний шалгалтын оноотой багш, судлаачийн үндсэн багшид эзлэх хувь (IELTS, TOEFL)	-	30%	50%
15	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	38%	47%	60%
16	Scopus-д бүртгэгдсэн хамтарсан судалгааны бүтээл	582	600	700

	Авьяастныг дэмжих түр журам ШУТИС-ЭШ-ЖУ01	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	2020.10.26 - 0
---	--	--	----------------------

# Авьяастныг дэмжих түр журам

Боловсруулсан:

Ажлын хэсэг

Хянасан:

Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал  
Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний алба

Дэмжсэн:

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ



## АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ .....	3
ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ҮҮРЭГ .....	4
ЗУРГАА. АВЬЯАСТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ .....	5
ДОЛОО. САНХҮҮЖИЛТ, ГЭРЭЭ .....	7
ХАВСРАЛТ 1. АВЬЯАСТНЫГ ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ .....	8
ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ .....	9

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 ШУТИС-ийн алсын хараа, эрхэм зорилгод хүрэх, сургалт, судалгааны үйл ажиллагааг өргөжүүлэх, чанар үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор авьяаслаг суралцагч, судлаачийг (цаашид “авьяастан” гэнэ) нээн илрүүлэх, чиглүүлэх, төвлөрүүлэх, дэмжин урамшуулахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Авьяастанг сонгон шалгаруулах үйл явц нь ил тод, нээлттэй, эрх тэгш, шударга өрсөлдөөнтэй, хараат бус байх зарчмыг баримтална.
- 1.3 Авьяастны дэмжлэгийг ШУТИС-ийн суралцагч, судлаачид сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг бүхэлд нь эсвэл тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусламж хэлбэрээр зарцуулна.

**ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ**


- 2.1 Авьяастны дэмжлэгийг ШУТИС-ийн суралцагч, судлаач наарт үзүүлнэ.
- 2.2 Энэхүү журам нь авьяастанг сонгон шалгаруулах, дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх үйл явцыг хамарна.

**ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ**

- 3.1 Боловсролын тухай хууль;
- 3.2 Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль (2011);
- 3.3 Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох журам (2017);
- 3.4 Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2018-2022);
- 3.5 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах хууль (2020);
- 3.6 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- 3.7 “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөө;

**ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

- 4.1 **Авьяас:** Шинэ мэдлэг, үр чадвар эзэмших болон ашиглах хувь хүний нөөц боломж; (UNESCO, 2013)
- 4.2 **Авьяастан:** Сэтгэн бodoх, шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх бүтээлч сэтгэлгээ нь дунджаас дээш түвшний чадвартай хувь хүн;
- 4.3 **Авьяастны дэмжлэг:** ШУТИС-ийн суралцагч, судлаачдыг чадварлаг багш, сургалт судалгааны таатай орчин нөхцлөөр хангах, урамшуулж, тэтгэлэг олгох үйл ажиллагаа;
- 4.4 **Судалгаа удирдагч багш:** авьяастныг чиглүүлж ажиллах, гурвалсан гэрээгээр үүрэг хүлээсэн багш;
- 4.5 **Шинжээчдийн зөвлөл:** Нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба үүнд сургалт, судалгаа хариуцсан нэгжээс-2, ШУТИС-ийн профессор, багшаас-3, хөндлөнгийн төлөөлөл (мэргэжлийн холбоод, оюутны холбоо, ажил олгогч, хандивлагч)-2 гишүүн байна.



## ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХҮҮРЭГ №087887

- 5.1 Авьяасыг дэмжих зардлын төсөв болон шинжээчдийн зөвлөлийг ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 5.2 Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгж
  - 5.2.1 Авьяасыг дэмжих зардлын төсвийн санал боловсруулна;
  - 5.2.2 Авьяасыг дэмжих хөтөлбөрийн холбогдох хэрэгжилтийг хангаж ажиллана;
  - 5.2.3 Авьяастанг нээн илрүүлэх, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тухай бүр мэдээлнэ;
  - 5.2.4 Шинжээчдийн зөвлөл байгуулах саналыг жил бүр боловсруулж, ШУТИС-ийн захирлын тушаал гаргуулна;
  - 5.2.5 Авьяасыг дэмжин санхүүжүүлэх байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллаж, үр дүнг жил бүр ШУТИС-ийн захирлын зөвлөлд тайлагнана;
  - 5.2.6 Сонгон шалгаруулалттай холбогдсон санал, хүсэлтийг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ;
  - 5.2.7 Шинжээчдийн зөвлөлийн дүгнэлт, шийдвэрт үндэслэн авьяастантай гурвалсан гэрээ байгуулах болон сунгах, цуцлах үүргийг хүлээнэ;
  - 5.2.8 Сонгон шалгаруулалт болон авьяастантай холбогдох мэдээ, тайлан бусад баримт бичгүүдийн мэдээллийн сан үүсгэн хамгаалж, түгээнэ.
- 5.3 Шинжээчдийн зөвлөл
  - 5.3.1 Авьяасыг дэмжих үйл ажиллагаатай холбогдсон аливаа асуудлыг хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ;
  - 5.3.2 Тухайн жилийн онцлогоос хамаарч авьяастныг сонгон шалгаруулах шалгуурт өөрчлөлт оруулах саналыг эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгжид хандан шийдвэрлүүлнэ;
  - 5.3.3 Авьяастны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэж, тэнцэгчдийн нэrsийн жагсаалт гаргаж, эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгжид хүлээлгэн өгнө;
  - 5.3.4 Гаргасан шийдвэр, авьяастны үнэлгээ, дүгнэлтийг бүрэн хариуцна;
- 5.4 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, захиргааны нэгж
  - 5.4.1 Тухайн сургууль, хүрээлэн, нэгж дотроо өөрсдийн зорилго, чиг үүргийн хүрээнд авьяастныг дэмжих үйл ажиллагааны төсөвт багтаан, тус журмын дагуу зохион байгуулж болно;
  - 5.4.2 Авьяасыг дэмжих үйл ажиллагааг таниулан сурталчилж, талуудын оролцоог хангана;
  - 5.4.3 Нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, анхан шатны шалгаруулалтыг хийнэ;
  - 5.4.4 Шалгарсан нэр дэвшигчийн материалыг албан бичгээр баталгаажуулж, эрдэм шинжилгээ, инновацийн хариуцсан эрхэлсэн нэгжид хургуулнэ;
  - 5.4.5 Дэмжлэг авсан авьяастнуудын гурвалсан гэрээний хэрэгжилтийг хангаж, ажиллана;
  - 5.4.6 Дэмжлэг авсан авьяастан олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлэхээр эрх авсан эсвэл олон улсын мэргэжлийн үзэсгэлэн, уралдаан, олимпиадад оролцох тохиолдолд гарах зардлыг сургуулийн төсөвт багтаан тодорхой хэмжээний санхүүжилт олгоно.


5.4.7 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, захиргааны нэгжийн Эрдмийн зөвлөл нь авьяастны сургалт, судалгааны ажлын явц, үр дүнг улирал бүр хэлэлцэн дүгнэж, тайланг Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгжид хүргүүлнэ.

#### 5.5 Авьяастан

- 5.5.1 Авьяастны дэмжлэг авах нөхцөл, болзол, шалгуур үзүүлэлтийн талаар холбогдох байгууллагаас мэдээлэл авна;
- 5.5.2 Авьяастны дэмжлэг авах шаардлага хангасан бол хүсэлтээ гарган сонгон шалгаруулалтад оролцно;
- 5.5.3 Гурвалсан гэрээгээр үүрэг хүлээж, холбогдох шаардлагыг хангаж ажиллана.
- 5.5.4 Авьяастны дэмжлэгийг үр ашигтай зарцуулж, сургалт судалгааны ажлын явц, үр дүнг тайлагнана;
- 5.5.5 Нэр дэвшигч нь авьяасыг дэмжих асуудлаар хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, буруу мэдээлэл өгсөн нь тогтоогдвол сонгон шалгаруулалтаас хасагдах бөгөөд үүнээс үүдэн гарах хариуцлагыг нэр дэвшигч өөрөө хүлээнэ.


### ЗУРГАА. АВЬЯАСТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- 6.1 Авьяастны дэмжлэгийн удирдамж, зарлал мэдээллийг анхан шатны сонгон шалгаруулалт болохоос 3 сарын өмнө их сургуулийн вэб хуудас болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр зарлаж, сонгон шалгаруулалтыг явуулна.
- 6.2 Авьяастны дэмжлэгийн сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай явуулна. Үүнд
  - 6.2.1 Бүрэлдэхүүн сургууль нь анхан шатанд баримт бичгийн бүрдэлд тавигдах шаардлага хангасан эсэхийг үнэлнэ. Үнэлгээгээр 80% буюу түүнээс дээш оногдох авсан нэр дэвшигч 2-р шатны шалгаруулалтад орно.
  - 6.2.2 Шинжээчдийн зөвлөл нь хоёр дахь шатанд шалгарсан нэр дэвшигчтэй ярилцлага, танилцуулга хэлбэрээр явуулж үнэлнэ.
  - 6.2.3 Сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагч, судлаачийн нэrsийг "Авьяастнуудад дэмжлэг олгох тухай" ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулж, батламж гардуулна.
  - 6.2.4 Сонгон шалгаруулалтад тэнцсэн авьяастны мэдээллийг ШУТИС-ийн вэб хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд зарлана.



## 6.3 Авьяастныг сонгох шалгуур буюу баримт бичгийн бурдэлт тавигдах шаардлага:

№	Нэр дэвшигч	Үндсэн шалгуур	Бүрдүүлэх материал
6.3.1	Бакалаврын түвшний суралцагч	<ul style="list-style-type: none"> <li>Шинэ бүтээл, бүтээлч санаа, шийдэл дэвшүүлсэн байх;</li> <li>Олон улсын, бүсийн болон тухайн салбарын чанартай үзэсгэлэн, уралдаан, тэмцээн, олимпиадад оролцож эхний 3-н байрт шалгарсан бол давуу тал болно;</li> <li>TOEFL IBT-70, IELTS-4.5 эсвэл TOEIC- 500 ба түүнээс дээш оноо авсан бол давуу тал болно;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нэр дэвшүүлсэн тухай албан бичиг, тодорхойлолт</li> <li>Нэр дэвшигчийн анкет</li> <li>Шинэ бүтээлч санаа, шийдлийн танилцуулга</li> <li>Дүнгийн тодорхойлолт</li> <li>Олимпиад, уралдаан тэмцээнд амжилт үзүүлснийг нотлох баримт</li> </ul>
6.3.2	Магистрын түвшний суралцагч	<ul style="list-style-type: none"> <li>Шинэ бүтээл, бүтээлч санаа, шийдэл бий болгосон байх;</li> <li>Олон улсын болон бүсийн чанартай үзэсгэлэн, уралдаан, тэмцээн, олимпиадад оролцож эхний 3-н байрт шалгарсан байх;</li> <li>Мэргэжлийн болон шинжлэх ухааны сэтгүүлд ЭШ өгүүлэл хэвлүүлсэн байх;</li> <li>TOEFL IBT-70 эсвэл IELTS 5.0-5.5 ба түүнээс дээш оноо авсан бол давуу тал болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нэр дэвшүүлсэн тухай албан бичиг, тодорхойлолт</li> <li>Нэр дэвшигчийн анкет</li> <li>Сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн тухай баримт</li> <li>Шинэ бүтээлч санаа, шийдлийн танилцуулга, бүтээл</li> <li>Олимпиад, уралдаан тэмцээнд амжилт үзүүлснийг нотлох баримт</li> <li>Цаашдын судалгааны ажлын төлөвлөгөө</li> </ul>
6.3.3	Докторын түвшний суралцагч	<ul style="list-style-type: none"> <li>Магистрын голч дүн 3.2-оос дээш байх;</li> <li>Өөрийн бүтээл, судалгааны үр дүнгээр оюуны өмчийн баталгаажуулалт хийсэн байх (патент, ашигтай загвар г.м.);</li> <li>Олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн эсвэл Scopus, Web Of Science, Томсон Ройтерс зэрэг индекстэй олон улсын хэмжээний сэтгүүлд судалгааны бүтээл хэвлүүлсэн байх;</li> <li>TOEFL IBT-80 эсвэл IELTS-6.0 ба түүнээс дээш оноо авсан байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нэр дэвшүүлсэн тухай албан бичиг, тодорхойлолт</li> <li>Нэр дэвшигчийн анкет</li> <li>Магистрын дипломын баталгаажуулсан хуулбар</li> <li>Хурал оролцсон, сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн тухай баримт</li> <li>Цаашдын судалгааны ажлын төлөвлөгөө</li> <li>Оюуны өмчийн баталгаажуулалт хийсэн баримт</li> <li>Хэлний түвшин тогтоосон батламж</li> </ul>
6.3.4	Докторын дараах судлаач (post-doc)	<ul style="list-style-type: none"> <li>Олон улсын зэрэглэл өндөр сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл сүүлийн 3 жилд 2-оос доошгүйг хэвлүүлсэн байх (1 өгүүлэл нь 1-р зохиогч эсвэл холбоо барих зохиогчоор хэвлэгдсэн байх);</li> <li>Өөрийн бүтээл, судалгааны үр дүнгээр оюуны өмчийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нэр дэвшүүлсэн тухай албан бичиг, тодорхойлолт</li> <li>Нэр дэвшигчийн анкет</li> <li>Докторын дипломын баталгаажуулсан хуулбар</li> <li>Бүтээлийн жагсаалт, хуулбар</li> </ul>



		баталгаажуулалт хийсэн байх (патент, ашигтай загвар г.м.).	<ul style="list-style-type: none"> <li>• Хурал оролцсон, сэтгүүлд егүүлэлт хэвлүүлсэн тухай баримт</li> <li>• Оюуны өмчийн баталгаажуулалт хийсэн баримт</li> <li>• Цаашдын судалгааны ажлын төлөвлөгөө</li> </ul>
--	--	---	--

## ДОЛОО. САНХҮҮЖИЛТ, ГЭРЭЭ

- 7.1 Авьяастныг дэмжих судалгааны чиглэл, санхүүжилтийн хэмжээ, хамрагдах хүний тоо, дэмжлэг олгох хугацааг тухайн жилийн ШУТИС-ийн төсөвтэй уялдуулж тогтооно.
- 7.2 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, захиргааны нэгж дотроо авьяасыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах тохиолдолд санхүүжилтийг сургалтын төлбөрөөс бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
- 7.3 Сургалтын төлбөрийг суралцагчийн суралцаж буй сургуулийн дансанд, амьжиргааны зардлыг суралцагчийн дансанд тус тус шилжүүлнэ.
- 7.4 ШУТИС-ийн эрдэм шинжилгээ инноваци хариуцсан нэгж – авьяастан - бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, нэгж, судалгаа удирдагч багш нарын харилцааг гурвалсан гэрээгээр зохицуулна.
- 7.5 Судалгаа удирдагч багш өөрийн судалгааны тесэл, хөтөлбөрөөс авьяасын дэмжлэг авсан суралцагчид нэмэлт санхүүгийн туслалцаа үзүүлж болно.
- 7.6 Гурвалсан гэрээнд талуудын эрх үүрэг, гэрээний хугацаа, судалгааны талаарх мэдээлэл, гэрээг сунгах нөхцөл, суралцагчийн голч дүнд тавигдах шаардлага, чөлөөлөгдөх нөхцөл, гэрээний заалт зөрчигдсөн тохиолдолд талуудын хүлээх хариуцлага, гэрээг цуцлах, санхүүжилтийг зогсоох зэргийг тодорхой тусгана.
- 7.7 Авьяасын дэмжлэг авсан суралцагч, судлаач чөлөө авсан эсвэл гэрээнд заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд санхүүжилтийг зогсоно.

## ХАВСРАЛТ 1. АВЬЯАСТНЫГ ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: [R] - Хариуцан хийж, гүйцэтгэх; [A] - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; [C] - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; [I] – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)				
				НД	ЭШИХН	БСХН	ШЗ	ДЗ
1	Хөтөлбөр Үйл ажиллагааны төлөвлөгөө		Зарлал Шалгаруулалтад тавигдах шаардлага	I	R	C	C	A
2	Тус журам Маягт ЭШ-М001		Шаардлагын дагуу бүрдүүлсэн материал	R	C	A		
3	Шаардлагын дагуу бүрдүүлсэн материал		Нэр дэвшүүлсэн тухай албан бичиг, тодорхойлолт	I	A	R	I	C
4	Нэр дэвшүүлсэн тухай албан бичиг, тодорхойлолт		Tэнцэгчдийн нэрсийн жагсаалт	I	C	I	R	A
5	Тэнцэгчдийн нэрсийн жагсаалт, бусад материал		ШУТИС-ийн захирлын тушаал	I	R	I	C	A
6	Тушаал Маягт ЭШ-М002		Гурвалсан гэрээ	C	R	C	C	A
7	Гурвалсан гэрээ		Явцын үnэлгээ, тайлан	C	A	R		I
8	Явцын үnэлгээ, тайлан Гурвалсан гэрээ		Мэдээллийн сан, гэрээ дүгнэсэн akt	I	R	I	C	A

\*НД- нэр дэвшисгч

\*ЭШИХН – эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нээж

\*БСХН- бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, захиргааны нэгж

\*ШЗ- шинжээчдийн зөвлөл

\*ДЗ- Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал

**ХАВСРАЛТ 2-ХОЛБОГОДХ МАЯГТ**

№	Маягтын нэр	Маягтын дугаар	Хадгалах эзэн/байршил
1	Нэр дэвшигчийн анкет	ЭШ-М001	ЭШИХН
2	Гурвалсан гэрээ	ЭШ-М002	ЭШИХН

**Маягт ЭШ-М001**

**ШУТИС-ын Авьяас хөтөлбөрт нэр дэвшигчийн анкет**

**Үндсэн мэдээлэл**

1. Эцэг /эх/-ийн нэр: \_\_\_\_\_ Өөрийн нэр: \_\_\_\_\_

Сүүлийн 3 сарын  
дотор авахуулсан  
цээж зураг

Ургийн овог: \_\_\_\_\_ Төрсөн он сар өдөр: \_\_\_\_\_ Хүйс: \_\_\_\_\_

Үндэс угсаа: \_\_\_\_\_

2. Төрсөн аймаг, хот:

\_\_\_\_\_

3. Оршин суугаа хаяг:

\_\_\_\_\_

4. Утас: 1 \_\_\_\_\_ 2. \_\_\_\_\_ /шаардлагатай тохиолдолд холбоо барих/

5. И-мэйл:

6. Сургууль:

7. Хөтөлбөр:

8. Харилцах банкны мэдээлэл: Банкны нэр: \_\_\_\_\_ Дансны дугаар: \_\_\_\_\_

9. Авахыг хүсэж буй дэмжлэг (доогуур нь зурна уу)

**Дэмжлэгийн төрөл**

- Сургалтын төлбөр
- Амьжирааны зардал

**Дэмжлэгийн хэлбэр**

- Бүхэлд санхүүжүүлэх
- Тодорхой хэсгийг санхүүжүүлэх  
(дэлгэрүүлж тайлбар бичих )

10. Боловсрол эзэмшсэн байдал (бүрэн дунд боловсролоос эхлэн бичих)

№	Сургуулийн нэр	Элссэн огноо	Төгссэн огноо	Голч оноо	ПЛАНЫН НОМРЭЛ ОХОО Эзэмшсэн боловсрол, мэргэжил, гэрчилгээ, дипломын дугаар

11. Гадаад хэл эзэмшсэн байдал (Англи хэлнээс бусад хэлний мэдлэгийн түшинг илтгэх мэдээллийг мөн бичих)

№	Шалгалтын нэр	Авсан оноо	Шалгалт өгсөн огноо
1	TOEFL/ IBT		
2	IELTS		
3	TOEIC		

12. Мэргэшлийн бэлтгэл (Мэргэжлийн болон бусад чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байдлыг бичнэ.)


Хаана, ямар байгууллагад	Эхэлсэн огноо	Хугацаа /хоногоор/	Ямар чиглэлээр	Үнэмлэх, гэрчилгээний дугаар, олгосон огноо

13. Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Ажилласан байгууллага, газар, түүний хэлтэс	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо

14. Судалгааны ажлын туршилагыг харуулах мэдээлэл /магистр, докторын хөтөлбөрт суралцагчид бөглөх/

№	Судалгааны сэдэв, хамрах хүрээ	Судалгааны бүтээлийн нэр	Тайлбар




## 15. Шагнал, тэтгэлгийн мэдээлэл

/ Сургууль, дүүрэг, нийслэл, улсын чанартай уралдаан, гадаадын орноос авсан шагнал болон тэтгэлгийг бичнэ/

No	Шагнал, тэтгэлгийн төрөл	Шагналын нэр	Тайлбар

## 16. Дэмжлэг авахыг хүсэгчдийн заавал бөглөх хэсэг:

ШУТИС-д суралцах хугацаандaa хийх судалгааны чиглэл, сэдэв, төлөвлөгөөг /Research plan/ бичих /report/

Төгсөөд цаашид ажиллахыг хүсэж буй салбар, ирээдүйн карьер төлөвлөөгөөг бичих

- Анкетыг гараар бөглөхгүй

Анкет үнэн зөв бөглөсөн: ..... /...../

Гарын үсэг

гарын үсгийн тайлал

2020 оны сар өдөр

Маягт ЭШ-М002

БАТЛАВ:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХАМТЫН АЖИЛЛАГАА  
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ .....

**“АВЬЯАСЫГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН  
ТАЛУУДТАЙ БАЙГУУЛАХ ГУРВАЛСАН ГЭРЭЭ**

20... оны ... сарын ...-ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Нэг талаас Шинжлэх ухаан, технологийн их сургууль (цаашид “ШУТИС” гэх)-ийг төлөөлж ..... сургуулийн/хүрээлэн/нэгжийн ..... /захирал/ ..... /эцэг, эхийн нэр/ ..... /өөрийн нэр/, нөгөө талаас судалгаа удирдагч багш ..... /эцэг, эхийн нэр/ ..... /өөрийн нэр/, гуравдагч талаас авьяас хөтөлбөрт тэнцсэн авьяастан ..... /эцэг, эхийн нэр/ ..... /өөрийн нэр/ (цаашид “авьяастан” гэх), (цаашид хамтад нь “Талууд” гэх) нар дараах нөхцөл, эрх, үүргийг харилцан тохиролцсоны үндсэн дээр төслийн гэрээ хэлэлцээр, Монгол Улсын Боловсролын тухай багц хуулиуд, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, ШУТИС-ийн холбогдох дүрэм, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Гэрээний зорилго нь “Авьяастныг дэмжих журам”-ын дагуу суралцагч, судлаачийг дэмжин урамшуулах, судалгааны ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, талуудын эрх үүрэг, хариуцлагыг энэхүү гэрээгээр зохицуулахад оршино.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

- 2.1 Авьяастан нь ШУТИС-д “\_\_\_\_\_” судалгааны чиглэлээр ..... (бакалаврын, магистрын, докторын, докторын дараах) сургалтын хөтөлбөрт хамрагдаж судалгаа хийж амжилттай суралцана.
- 2.2 Авьяастан нь нэг /хичээлийн жил, хоног/ урамшуулал, тэтгэлэгт хамрагдах ба хугацааг тооцохдоо Иргэний хуульд заасан хугацаа тоолох журмын дагуу хуанлийн тооллыг баримтална. /судалгааны ажлыг эхлэх, дуусах огноог тодорхой бичих/  
Бүтээл/Судалгааны ажил хийж эхлэх хугацаа .....  
Бүтээл/Судалгааны ажлыг дуусгах хугацаа .....
- 2.3 Авьяасыг дэмжих сангаас судлаачид олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын санхүүжилтийн хуваарь:

№	Хугацаа	Санхүүжилтийн хэмжээ /төг/		
		Нийт	Үүнээс /төг/	
			Сургалтын төлбөр	Амьжиргааны зардал
1	Намрын улирал	.....	.....	.....
2	Хаврын улирал	.....	.....	.....

- 2.4 Талууд гэрээнд тусгаагүй асуудлыг Монгол Улсын Иргэний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон шийдвэрлэнэ.



### Гурав. Талуудын эрх, үзүүлэг

- 3.1 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, захиргааны нэгж, удирдагч багш:
- 3.1.1 Авьяастныг энэхүү гэрээний 2.2-т заасан хугацаанд тухайн судалгаа удирдагч багшийн шууд удирдлаган дор суралцуулах бөгөөд сургалт, судалгааны орчноор хангаж, судалгааны ажилтай холбоотой туршилт гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх;
  - 3.1.2 Авьяастныг мэргэжлийн профессоруудаас зөвлөгөө авах, сургалт, судалгаатай холбоотой материал цуглуулах, судалгааны ажлаа мэргэжлийн эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
  - 3.1.3 Авьяастан эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;
  - 3.1.4 Авьяастны сургалт, судалгааны үүргээ хэрхэн биелүүлж байгаа болон туршилт, судалгааны үр дүнд хяналт тавих;
  - 3.1.5 Авьяастнаас сургалт судалгааны ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргах, удирдамж, чиглэл өгч ажиллах;
  - 3.1.6 Авьяастнаас судалгааны ажлын явц болон эцсийн үр дүн, тайлан мэдээ, тайланг гаргуулж, нэгтгэн Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгжид хүлээлгэн өгөх, тайлангийн үр дүнг хэлэлцүүлэх.
- 3.2 Эрдэм шинжилгээ, инноваци хариуцсан нэгж
- 3.2.1 Сонгогдсон авьяастантай гурвалсан гэрээ хийх, хөтөлбөрт хамрагдах хугацаанд хамаарах судлаачийн санхүүжилтийн тооцоог хуваарийн дагуу шуурхай шилжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
  - 3.2.2 Гэрээнд заасан үүргээ биелүүлж ажиллахыг талуудаас шаардах;
  - 3.2.3 Гэрээний хэрэгжилттэй холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэх;
  - 3.2.4 Тэтгэлгээр суралцаж буй судлаач болон гүйцэтгэж буй судалгааны ажлын үр дүнг мэдээлэх, түгээн дэлгэрүүлэх;
  - 3.2.5 Авьяастны сургалт, судалгааны явц, үр дүнгийн талаар бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, нэгжээс судалгаа авч, үр дүнгийн тайланг үндэслэн судлаачийн гэрээг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, дуусгавар болгох;
  - 3.2.6 Авьяастан хүндэтгэх шалгаангүйгээр сургалт, судалгааны ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан тохиолдолд гэрээг цуцлах.
- 3.3 Авьяастан
- 3.3.1 Авьяастан нь бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн лаборатори, сургалтын орчныг ашиглах, мэргэжлийн профессор багш нараас зөвлөгөө авах;
  - 3.3.2 Авьяастан нь олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэхээр тэнцсэн, эсвэл олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх болсон бол бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, нэгжээс дэмжлэг авах;
  - 3.3.3 Авьяастан нь авьяастныг дэмжих журмыг мөрдөж ажиллах;
  - 3.3.4 Авьяастан нь батлагдсан судалгааны сэдвийн хүрээнд сургуулиас өгөгдсөн удирдамжийн дагуу удирдагч багштай хамтран судалгааны зорилго, хүрэх үр дүнгийн талаар төлөвлөгөө /хөтөлбөр/ боловсруулан бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн ЭНБ-ээр хянуулан, захирлаар батлуулж ажиллах;
  - 3.3.5 Авьяастныг дэмжих санхүүжилтээр хийгдсэн судалгааны сэдэв, хийсэн туршилт, нээсэн шинэ санаа зэргийн зохиогчийн эрхийг Монгол Улсын Оюуны өмчийн хууль тогтоомж, ШУТИС-д мөрдөгдөж буй дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэх;
  - 3.3.6 Авьяастан нь дэмжлэгийн хугацаанд бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, судалгааны багийн судалгааны удирдагч багштай тогтмол харилцаа холбоотой байж улирал тутамд 1 удаа, удирдамжид заагдсан судалгааны ажлын тайлан мэдээг бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, судалгааны багийн удирдагч, ЭНБД-аар баталгаажуулан, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;

3.3.7 Онцлогоос хамаарсан нэмэлт заалт;



**Дөрөв. Хүлээх хариуцлага**

- 4.1 Авьяастан дэмжлэгт хамрагдах хугацаанд сахилгын зөрчил гаргаж сургуулиас хөөгдсөн, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалт, судалгааны ажлаа орхисон тохиолдолд гаргасан санхүүжилтийн зардлыг эргүүлэн төлнө.
- 4.2 Энэхүү гэрээний 3.2.6, 3.3.4, 3.3.5, 3.3.6 заалтыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.
- 4.3 Судалгааны удирдагч багшийн саналаар гэрээг цуцалж болно.

**Тав. Бусад зүйл**

- 5.1 Гэрээг 3 хувь үйлдэж, гэрээ байгуулсан талууд гэрээний хугацааг дуустал хадгална. Талуудад хадгалагдсан хувиуд нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин эзлэсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсвэл биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.
- 5.3 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн маргааныг Талууд харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.4 Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

**Зургаа. Гэрээ байгуулсан**

**Бүрэлдэхүүн сургууль,  
хүрээлэн, нэгжийн захирал**

**Судалгааны ажлын  
удирдагч**

**Авьяастан  
(суралцагч, судлаач):**

Албан тушаал:

Албан тушаал:

Эцэг /эх/-ийн нэр:

Эцэг /эх/-ийн нэр

Эцэг /эх/-ийн нэр:

Өөрийн нэр:

Өөрийн нэр

Өөрийн нэр:

Регистр:

Гарын үсэг .....

И-мэйл:

Утас:

(тамга, тэмдэг)

Гарын үсэг .....

И-мэйл:  
Гарын үсэг .....